

## “ТАЛЫН ГАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2018 оны 4 дүгээр  
сарын 30-ны өдөр

Дугаар 1

Рашаант

Хурал 2018 оны 4 сарын 30-ны өдрийн 14,00 цагаас компанийн хурлын танхимд эхлэв. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн 2018 оны ээлжит хурал хуралдуулах товыг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 3-р сарын 5-ны өдрийн 02 тоот тогтоолоор гаргасан бөгөөд хурлын зарыг “Өнөөдөр” MN өдөр тутмын сонины 2018 оны 3 дугаар сарын 8-ны өдрийн №044 /6337/, 3 дугаар сарын 23-ны өдрийн №054 /6347/ дугааруудад тавьж нийтлүүлсэн бөгөөд хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгааг “Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн 2018 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 01/674 тоотоор гаргуулсан болно.

“Талын гал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрээр Тооллогын комиссын даргаар компанийн Хянан шалгагч Ш.Мягмарсүрэнг, гишүүдээр ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Баярмандах, ня-бо Б. Урнаа нарыг тус тус томилсон болно.

Тоологын комиссын танилцуулсанаар хуралд тус компанийн нийт 694264 хувьцаа эзэмшигч, 27 хүн хуралд оролцохоос нийт 683546 хувьцаа эзэмшигч 3 хүн ирж, хурлын ирц 98,5 хувь болсон тул хурлыг 14,00 цагаас эхлүүлэв. Тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Т.Болдын санал болгосноор хурлын даргаар хувьцаа эзэмшигч У.Батсуурь, нарийн бичгийн даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн С.Цэрэндондов нарыг санал нэгтгэйгээр сонгов. Хурлын дарга У.Батсуурь “Талынгал” ХК-ийн 2018 оны ээлжит хурлаар хэлэлцэх асуудал, хурлын дэгийг хуралд оролцогчдоор хэлэлцүүлэн батлуулав. Хурлаар хэлэлцсэн асуудлууд, хурлын дэгийг хавсаргав.

Хурлаар хэлэлцэх асуудлуудыг дарааллын дагуу, хурлын дэгийн хүрээнд хэлэлцэж, урьдчилан зөвшилцөж тохиролцсоны дагуу хэлэлцсэн асуудал тус бүрээр хувьцаа эзэмшигчид саналаа чөлөөтэй илэрхийлж, хариулт авч байв.

Хурлаар хэлэлцсэн асуудлаар гаргах шийдвэрийн төсөлд хувьцаа эзэмшигчдийн гаргасан саналыг Тооллогын комисс саналын хуудсаар авч, нэгтгэн, баталгаажуулж, Тооллогын комиссын гаргасан 01 тоот тогтоолыг комиссын дарга Ш.Мягмарсүрэн танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн 2018 оны ээлжит хурлаас тооллогын комиссын дээрхи шийдвэрийг зөвшөөрч дараах шийдвэрүүдийг гаргав. Үүнд:

1. Компанийн 2017 оны үйл ажиллагаа, ТУЗ-ийн тайлангийн тухай тогтоол
2. Компанийн Хянан шалгагчийн тайлан, дүгнэлтийн тухай тогтоол
3. Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах тухай асуудлыг компанийн ТУЗ-ийн гишүүн Т.Болд танилцуулав. Тус компанийн хувьцаа эзэмшигчдэд нэгж хувьцаа тутамд 50,0 /тавин/ төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар тогтов.
4. Төлөөлөн удирдах зөвлөл, Хянан шалгагчийн 2018 оны төсөв батлах тухай тогтоол эдгээр болно.

Хурал хэлэлцэх асуудлаа хэлэлцэж дууссан тул 16,20 цагт дуусав.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ХУРЛЫН ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



УБАТСУУРЬ

С.ЦЭРЭНДОНДОВ